



**THE MEMORANDUM OF UNDERSTANDING
BETWEEN THE MINISTRY OF FOREIGN AFFAIRS OF MONGOLIA AND
THE MINISTRY OF FOREIGN AFFAIRS AND TRADE PROMOTION OF THE
REPUBLIC OF MALTA
ON THE ESTABLISHING OF MECHANISM FOR POLITICAL CONSULTATION**

The Ministry of Foreign Affairs and Trade Promotion of the Republic of Malta and the Ministry of Foreign Affairs of Mongolia, (hereinafter referred to as the Parties);

Wishing to further develop and strengthen the traditionally friendly relations and cooperation between the two countries,

Striving to promote cooperation in the political, economic, cultural and other fields between the two countries,

Believing that consultations and exchange of information and views on mutually interested bilateral, regional and international issues will be beneficial to the deepening of mutual understanding,

Guided by the 1961 Vienna Convention on Diplomatic Relations,

Have agreed as follows:

Article 1

The Parties will hold consultative meetings at senior officials' level to discuss modalities of expanding and deepening the cooperation for the development of bilateral relations as well as international issues of common interest.

Article 2

1. The Parties will hold these consultations as decided by the parties, alternately in Ulaanbaatar and Valletta or between the Permanent Missions in the United Nations and its specialized agencies and other international organizations or at the international conferences.

2. Diplomatic Missions of the two countries stationed in third countries and accredited to the Parties will consult and exchange information on the issues of mutual interest.

Article 3

A handwritten signature in the bottom right corner of the page.

The Parties will decide on the delegations, specific dates, venue and agenda of the consultative meetings through diplomatic channels.

Article 4

The Parties will, within their competence, look for new forms to develop relations between the two countries in every and in different levels.

Article 5

This Memorandum of Understanding may be amended upon mutual consent of the Parties in writing through the exchange of diplomatic notes.

Article 6

Any difference between the Parties concerning the implementation and interpretation of this Memorandum of Understanding will be settled amicably through consultations or negotiations.

Article 7

1. This Memorandum of Understanding will come into effect on the date of its signature and will remain in effect for a period of five (5) years. After each term, it will be extended automatically for another five (5) year period unless either Party notifies the other Party in writing, six months prior to the expiration of the term, of its intention to terminate the Memorandum of Understanding.

2. Either Party may terminate this Memorandum of Understanding at any time by giving a written notification to other Party of its intention to terminate the Memorandum of Understanding six months prior to the intended date of termination.



Done in New York on this day 24 September 2019, in two original copies, each in English and Mongolia languages, both texts having equal validity.



**FOR THE MINISTRY OF FOREIGN
AFFAIRS AND TRADE PROMOTION
OF THE REPUBLIC OF MALTA**

H.E. Mr. Carmelo Abela,
Minister for Foreign Affairs and Trade
Promotion

**FOR THE MINISTRY OF FOREIGN
AFFAIRS OF MONGOLIA**

H.E. Mr. Tsogtbaatar Damdin,
Minister for Foreign Affairs



**УЛС ТӨРИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН МЕХАНИЗМ БАЙГУУЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ,
БҮГД НАЙРАМДАХ МАЛЬТА УЛСЫН
ГАДААД ХЭРЭГ, ХУДАЛДААНЫ ЯАМ ХООРОНДЫН
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын Гадаад харилцааны яам болон Бүгд Найрамдах Мальта Улсын Гадаад хэрэг, худалдааны яам (цаашид "Талууд" гэх),

Хоёр улсын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам бүр бэхжүүлэн хөгжүүлэхийг хүсч,

Хоёр улсын хооронд улс төр, эдийн засаг, соёлын болон бусад салбарт хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихийг чармайж,

Олон улсын, бүс нутгийн болон хоёр талын харилцан сонирхсон асуудлаар мэдээлэл, санал солилцож, зөвлөлдөх нь харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд тустай гэдэгт итгэж,

Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенцыг удирдлага болгон,

Дараахь зүйлийг тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

Талууд хоёр талын харилцааг хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх арга хэлбэр, түүнчлэн нийтлэг ашиг сонирхолд нийцсэн олон улсын асуудлаар хэлэлцэх зорилгоор зөвлөлдөх уулзалтыг ахлах албан тушаалтны түвшинд зохион байгуулна.

2 дугаар зүйл

1. Талуудын шийдвэрлэснээр энэхүү зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар болон Валлета хотноо ээлжлэн, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллага болон олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар хооронд, эсхүл олон улсын бага хурлын үеэр зохион байгуулна.

2. Талуудын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрууд харилцан сонирхсон асуудлаар зөвлөлдөж, мэдээлэл солилцож болно.

3 дугаар зүйл

Талууд зөвлөлдөх уулзалтын хэлэлцэх хэрэг, тодорхой тов, газар болон төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг дипломат шугамаар тохиролцоно.

4 дүгээр зүйл

Талууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хоёр улсын харилцааг аль ч түвшинд хөгжүүлэх шинэ хэлбэрийг эрэлхийлнэ.

5 дугаар зүйл

Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр бичгээр ноот бичиг солилцох замаар энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6 дугаар зүйл

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн аливаа зөрүүг Талууд зөвлөлдөх, эсхүл хэлэлцээ хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл

1. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь түүнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба таван (5) жилийн хугацаанд хүчинтэй байна. Аль нэг Тал энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг цуцлах тухайгаа түүний хүчинтэй хугацаа дуусахаас зургаан сарын өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол санамж бичгийн хүчинтэй хугацаа нь таван (5) жилээр аяндаа сунгагдана.

2. Аль ч Тал энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг цуцлах тухай хүсэлтээ тийнхүү цуцлах хугацаанаас зургаан сарын өмнө нөгөө Талдаа хэдийд ч бичгээр мэдэгдэж харилцан ойлголцлын санамж бичгийг цуцалж болно.

Нью-Йорк хотноо 9-р сарын 24-ны өдөр монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.



**БҮГД НАЙРАМДАХ МАЛЬТА
УЛСЫН ГАДААД ХЭРЭГ,
ХУДАЛДААНЫ ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ**

Бүгд Найрамдах Мальта Улсын
Гадаад хэрэг, худалдааны сайд
Кармело Абела



**МОНГОЛ УЛСЫН ГАДААД
ХАРИЛЦААНЫ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Монгол Улсын Гадаад харилцааны
сайд Дамдины Цогтбаатар